# ГАДААД ДОТООДЫН ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ТАНИЛЦУУЛГА

## Та бүхэн солонгост улсад тавтай морилно уу.

Манай улсад оршин сууж байх хугацаандаа эрүүл саруул оршин суухад дэмжлэг үзүүлэхийн тулд эрүүл мэндийн даатгалын тогтолцоог ашиглах талаар танилцуулж байгаа тул анхааран хүлээн авна уу.

## Эрүүл мэндийн даатгал гэж юу вэ?

Өвдөх болон бэртэж гэмтсэний улмаас эмчлүүлэх үед нь эрүүл мэндийн даатгалд хамруулсанаар эрүүл мэндийг хамгаалж, нийгмийн халамжийг сайжруулах зорилгоор гадаадын иргэдийг ч гэсэн солонгос иргэдийн нэгэн адил эрүүл мэндийн даатгалд хамруулж байна.

## Даатгалд хамрагдах хүмүүс?

### Ерөнхий шаардлага

- **“Хилийн шалган нэвтрүүлэх тухай хууль”-ийн 31-р зүйлд заасны дагуу гадаадын иргэний бүртгэл хийгдсэн гадаадын иргэд**
- **“Гадаадад амьдардаг солонгос үндэстүүдийн хилээр орж гарах, тэдний эрх зүйн байдлын тухай хууль”–ийн 6-р зүйлд заасны дагуу бүртгүүлсэн нутаг нэгтэн**
- **“Иргэний бүртгэлийн тухай хууль”-ийн 6-р зүйлд заасны дагуу иргэний бүртгэл хийлгэсэн гадаадад оршин суугч солонгос иргэн**

### Даатгалд хамрагдах ажил эрхлэгч

- **Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг аж ахуйн нэгжид ажиллаж буй ажилтан болон ажил олгогч**
  - Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг аж ахуйн нэгжид ажиллаж буй гадаадын иргэн
    ※ Франц иргэдийн тохиолдолд эрүүл мэндийн даатгалд хамрагддаг ажилтан бол сайн дурын даатгалд хамрагдах боломжтой (Нийгмийн халамжийн хэлэлцээр байгуулсан)
- **Доор дурьдсан тохиолдолд даатгалд бүртгүүлэхгүйгээр хүсэлт гаргаж болно.**
  - Гадаадын хууль журам болон даатгалын дагуу эрүүл мэндийн даатгалд хамрагдаж буй ажилтан
  - Ажил олгогчтой гэрээ хийсний үндсэн дээр эрүүл мэндийн даатгалд хамрагдаж буй ажилтан

### Байнга оршин суугч

- **Доорх визний ангилалтай ажилтан эсвэл даатгуулагчийн гэр бүл биш гадаадын иргэд өөрөө хүсэлт гарган даатгалд хамрагдаж болно.**
  - Оршин сууж буй визний ангилал: F-1(Гэр бүлийн хамт оршин суух), F-2(Оршин суух), F-3(Хамт амьдрах), F-4(Гадаадад амьдардаг солонгос үндэстэн), F-5(Байнгын оршин суугч), F-6(Гэрлэлт), D-1(Соёл урлаг), D-2(Оюутан), D-3 (Үйлдвэрлэлийн дадлага), D-4(Дадлага), D-5(Сурвалжлага), D-6(Шашин), D-7(Дипломат төлөөлөгч), D-8(Хөрөнгө оруулагч), D-9(Гадаад худалдаа менежмент), D-10(Ажил хайх), E-1(Багш), E-2(Ярианы дадлагын багш), E-3(Судалгаа), E–4(Техникийн мэргэжилтэн), E-6(Соёлын үйл ажиллагаа), E-7(Тусгай үйл ажиллагаа), E-9(Мэргэжлийн бус ажилчин), E-10(Усан онгоцны ажилчин), H-1(Аялал жуулчлалын ажилтан), H-2(Ажиллах), Гадаадад буй иргэд

## Даатгалд хамрагдах дэс дараалал болон бүрдүүлэх материал

### Ажил эрхэлдэг даатгуулагч:

- **Ажил олгогч нь ажилтныг даатгалд хамруулах хүсэлт гаргахдаа гадаадын иргэний оршин суух үнэмлэх (эсвэл нутаг нэгтний оршин суух үнэмлэх)-ний хуулбар эсвэл гадаадын иргэний бүртгэлийн лавлагаа (солонгос үндэстний бүртгэлийн лавлагаа)-г хавсаргана.**

### Байнга оршин суугч

- **Гадаадын иргэний оршин суух үнэмлэх (эсвэл солонгос үндэстний оршин суух үнэмлэх)-ний хуулбар эсвэл гадаадын иргэний бүртгэлийн лавлагаа (нутаг нэгтний бүртгэлийн лавлагаа) болон эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын хавсралт 10-т заасны дагуу оршин суугаа ангилалд хамаарах бичиг баримт тус бүр 1 хувийг хавсарган даатгалын сангийн салбарт өргөдөл гаргана.**

## Даатгалд хамрагдах хугацаа

### Ажилтан

- **Ажилд орсноос хойш**

### Ажилтны гэр бүл

- **Хүсэлт гаргаснаас хойш, эрх үүссэн өдрөөс хойш 90 хоногийн дотор бүртгүүлсэн тохиолдолд эрх үүссэн өдрөөс хойш тооцно.**

### Байнгын оршин суугч

- **Солонгосын хилээр орж ирсэн өдрөөс хойш (Хамгийн сүүлд орж ирсэн өдрөөс) 3 сар өнгөрсны дараа тооцно.**
- **Хилээр орж ирснээс хойш 3 сар боловч ажилд орсон, сургуульд суралцаж буй, гэрлэсэн гэдэг шалтгаанаар 3-аасдээш сар оршин суух нь тодорхой байгаа тохиолдолд хилээр орж ирсэн өдрөөр тооцно.**

## Даатгалын хураамжийн хэмжээ, төлөх арга

### Ажилтан

- **Сард төлөх даатгалын хэмжээ=сарын цалин х даатгалын шимтгэлийн хувь (даатгалын хураамж төлөх харьцаа: ажилтан өөрөө 50%, ажил олгогч 50%)**
- **Даатгалын хураамжийг цалингаас шууд суутган тооцно.**

### Байнга оршин суугч

- **Орлого тодорхойлох боломжтой гадаадын иргэн (D-3, D-5-9, E-1-7, E-9-10, H-1-2)**
  - Сард төлөх даатгалын хэмжээ=сарын цалин х даатгалын шимтгэлийн хувь
  - Шашны ү.а -D-6 визээр оршин сууж буй тохиолдолд даатгалын хураамжаас 30% хүртэл хөнгөлнө.
  - Даатгалын хураамж өмнөх жилийн эцсийн даатгалын дундаж хэмжээнээс доош байгаа тохиолдолд өмнөх жилийн эцсийн даатгалын дундаж хэмжээгээр тооцно.
- **Орлогогүй эсвэл орлого тодорхойлох боломжгүй гадаадын иргэн (D-1-2, D-4, D-10, F-3)**
  - Өмнөх жилийн эцсийн даатгалын дундаж хэмжээ
  - Хэлний бэлтгэл (D4), Оюутны (D2) визээр оршин сууж байгаа бол даатгалын хураамжаас 50% хөнгөлнө.
- **Солонгост байнга оршин сууж буй гадаадын иргэн (Гэр бүлийнхэнтэйгээ оршин сууж буй -F-1, Удаан хугацаагаар оршин суух -F2, Байнга оршин суугч -F5, Гэрлэлтээр оршин суугч -F6)**
  - Солонгос иргэдтэй нэг адил хэмжээгээр даатгалын хураамж төлнө.

Monglian

- **Гадаадад амьдардаг солонгос үндэстэн (F-4) ба гадаадад оршин суудаг солонгос иргэдийн даатгалын хураамж нь дотооддоо байгаа солонгос иргэдийн нэгэн адил байна.**
  - Даатгалын хураамж өмнөх жилийн эцсийн даатгалын дундаж хэмжээнээс доош байгаа тохиолдолд өмнөх жилийн эцсийн даатгалын дундаж хэмжээгээр тооцно. Харин оюутан бол 50% хүртэл хөнгөлнө.
- **Гадаадын иргэн (Гадаадад амьдардаг солонгос үндэстэн) байнгын оршин суугч нь тухайн сарын даатгалын хураамжийг өмнөх сарын 25-ны дотор төлнө.**
  - Тухайн нөхцөл бүрт тохирсон даатгалын хураамжийг анх мэдүүлсэн даатгалын хураамж дээр нэмж тооцно.

## Даатгалын хөнгөлөлт

- **Солонгос иргэдийн нэгэн адил даатгалд хамрагдан хөнгөлөлт эдлэнэ.**
  - Эмнэлэг болон эрүүл мэндийн байгууллагад хэвтэж эмчлүүлэх бол эмчилгээний зардлын 80%-ийг даатгалын сангаас хариуцаж амбулаториар үйлчлүүлэх тохиолдолд 40-70%-ийг даатгалын сан хариуцаж байгаа бөгөөд жирэмсэн эхчүүдэд төрөхөд нь халамжийн мөнгө өгч байна. Өвчний талаарх мэдээлэл болон урьдчилан сэргийлэх мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлж байна.

## Эрүүл мэндийн сангаас үзүүлж буй эрүүл мэндийн үзлэгүүд

- **Эрүүл мэндийн ерөнхий үзлэгт хамруулснаар цусны даралт, чихрийн шижин зэрэг зүрх судас, тархины өвчлөлүүдээс урьдчилан сэргийлж, өвчнийг эрт илрүүлэх бөгөөд үзлэгт 40-өөс дээш насны хүмүүсийг төрсөн он(тэгш, сондгой тоотой он)-д нь тохируулан 2 жилд нэг удаа хамруулж, өрхийн тэргүүн бөгөөд орон нутгийн даатгуулагч, ажил эрхлэгч даатгуулагчийг нас харгалзахгүй хамруулж, офисын бус ажил эрхэлдэг даатгуулагчийн хувьд 1 жилд 1 удаа үзлэгт хамруулна.**
- **Тодорхой заасан насанд хүрсэн 40 нас, 66 настай хүмүүст ерөнхий шинжилгээний үндсэн шинжилгээ, нас насанд нь тохируулсан шинжилгээ (элэгний В вирус, ясны сийрэгжилт, сэтгэц г.м), амьдралын зуршлын үнэлгээ зэргийг хийж өгч, шинжилгээний хариуг тайлбарлан зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлнэ.**
- **Хорт хавдрыг эрт илрүүлж, эмчлэхийн тулд 5 төрлийн хорт хавдрын шинжилгээнд хамруулж байгаа бөгөөд ходоод, хөхний хорт хавдрын шинжилгээнд 40 –өөс дээш насны хүмүүс, бүдүүн гэдэсний хорт хавдрыг 50-аас дээш насных, умайн хүзүүний хорт хавдрыг 20-иос дээш насны эмэгтэйчүүд, элэгний хорт хавдрыг элэгний хавдарт өртөх өндөр эрсдэлтэй хүмүүс дундаас 40 –өөс дээш насны хүмүүсийг хамруулна. Үзлэгт хамрагдах хугацаа нь ходоод, хөх, умайн хүзүүний хорт хавдрын үзлэг 2 жилд 1 удаа, бүдүүн гэдэсний хорт хавдрын үзлэг 1 жилд 1 удаа, элэгний хорт хавдрын үзлэг 6 сард 1 удаа байна.**
- **Нярай болон бага насны хүүхдийг эрүүл саруул өсөж бойжиход тустай эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зайлшгүй хийлгэх үндсэн шинжилгээ, өсөлт бойжилтын үнэлгээ, эрүүл мэндийн сургалт зэргийг явуулж, хүүхэд асрах зөвлөгөө өгнө. Үзлэгт 6 хүртэлх насны хүүхдийг хамруулах бөгөөд төрсөн цагаасаа хойш 4 сар, 9 сар, 18 сар, 30 сар, 42 сар, 54 сар, 66 сартай байх үедээ амны хөндийн үзлэгээс эхлэлд нийт 10 төрлийн үзлэгт хамрагдаж болно.**
- **Оршин суух хаягаас үл хамааран орон даяар аль ч заасан үзлэг хийх байгууллагад очиж эрүүл мэндийн үзлэгт хамрагдах боломжтой.**

## Өндөр настнуудаан хугацааны сувиллын даатгалын үйлчилгээ:

- **Өндөр настны удаан хугацааны сувиллын даатгал гэдэг нь?**
  - Өндөр настан болон уймраа, саажилт, паркинсоны өвчин зэргийн улмаас ганцаараа бие даан амьдрах боломжгүй, удаан хугацааны сувилгаа шаардлагатай гэдэг нь хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд даатгуулагчийн гэрт эсвэл урт хугацааны асрамжийн газарт (асрамжийн газар, өдөр оройн цагаар харах үйлчилгээ, богино хугацаагаар харах үйлчилгээ) биеийн хөдөлгөөнийг дэмжих ба бие сэтгэлийн үйл ажиллагаа хэвийн байлгах, сайжруулах чиглэлийн сургалт, дасгал, танин мэдэхүйн хөлбөрт хөтөлбөр г.м удаан хугацааны сувиллын үйлчилгээ авах боломжтой тогтолцоо (2008.7.1)
- **Удаан хугацааны сувиллуулах хүсэлт гаргах?**
  - Ганцаараа бие даан амьдрахад бэрхшээлтэй 65-аас дээш насны өндөр настан, эсвэл 65 нас хүрээгүй өвчтөн бол шуудангаар болон факс, интернет (www.longtermcare.or.kr ) болон биеэр иржхүсэлт гаргаж болно.
- **Даатгуулагчийн хариуцах зардал**

| Даатгуулагчийн гэрт | Асрамжийн газарт |
|---|---|
| Өндөр настны удаан хугацааны сувиллын даатгалын 15/100 | Өндөр настны удаан хугацааны сувиллын даатгалын 20/100 |

- **Гадаад ажилчид дундаас D-3 (үйлдвэрийн дадлага), E-9 (Мэргэжлийн бус ажилчин), H-2 (Ажиллах) визний ангилалтай ажилчид удаан хугацааны сувилуулалын даатгалт бүртгүүлэхгүйгээр хүсэлт гаргаж болно.**

## Эрүүл мэндийн даатгалд хууль бусаар хамрагдсан этгээдэд хүлээлгэх хариуцлага

- **Эрүүл мэндийн даатгалд хууль бусаар хамрагдсан этгээдэд эрүүгийнхариуцлага хүлээлгэнэ.**
  - Эрүүл мэндийн даатгалын дэвтэр эсвэл биеийн байцаалтаа өөр хүнд дамжуулах эсвэл бусдын эрүүл мэндийн даатгалын дэвтрийг ашиглан эмчилгээ хийлгэсэн тохиолдолд
  - Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 115-р зүйл (Хавсралт) 3-ын 5-д заасанаар хуурамч үйлдэл болон хууль бус ямар нэгэн аргаар эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсвэл өөр хүнийг даатгалд хамруулсан бол 1 жил хүртэлх хугацаагаар хорих эсвэл 10 сая хүртэлх воноор торгох ял шийтгэл оногдуулна.
- **Эрүүгийн хариуцлага хүлээсэн талаарх мэдээллийг хилийн шалган нэвтрүүлэх алба (имигрэшн)-рүү явуулсанаар хилээр орох эрх хаагдах, оршин суух хугацаа сунгахыг хориглох зэрэг асуудлууд үүсэж болно.**



**Бусад лавлах зүйлийг**
Homepage www.nhis.or.kr
Утас 1577-1000(Орон даяар)
(033) 811-2000(Англи хэлээр зөвлөгөө өгөх)

Monglian